



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР 2016 ОНД ХЭРЭГЖСЭН
ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ



Өвөрхангай аймгийн ХЭДСангийн 2016 оны орлогын бүрдүүлэлт,
хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн хангалтгүй байна.

Арвайхээр 2017 он

ААГ-НАБ/2017/01-НА

Агуулга

<p>ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР</p> <p>Тайланг бэлтгэсэн:</p> <p><i>Дарга, тэргүүлэх аудитор Л.Ламаачин</i></p> <p><i>Аудитын менежер Ц.Отгонням</i></p> <p><i>Ахлах аудитор Д.Гансүх</i></p> <p><i>Аудитор П.Хорлоосүрэн</i></p> <p>2017 оны 6 дугаар сар</p> <p>Уг тайлаяг ААГ-ын www.audit.mn Facebook хаягаар орж үзнэ үү.</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал:</p> <p>утас: 70323108, факс 70323253</p> <p>ХАЯГ:</p> <p>(Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5 дугаар баатар, Нутгийн удирдлагын ордон 402 тоот)</p>	<p>Товчилсон үгийн тайлбар</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</p> <p>Бүлэг-1 ХЭДСангийн үйл ажиллагааны орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт хангалтгүй байна.</p> <p>Бүлэг-2 Аймгийн ХЭДСангийн хөрөнгө хууль, журмын дагуу зарцуулагдаж, төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа ч тодорхой үр дүнд хүрээгүй байна.</p> <p>Бүлэг-3 Сангийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт хийгдэж, хяналтын үр дүн гарч байна.</p> <p>Хавсралт судалгаа</p>
---	--

ТОВЧИЛСОН УГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
НББ	Нягтлан бодох бүртгэл
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НАБ	Нийцлийн аудитын баг
ЗД	Засаг дарга
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ЗГ	Засгийн газар
ЭБЦТС	Эрдэнэт Булганы Цахилгаан Түгээх Сүлжээ
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭДТ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай
ТББ	Төрийн бус байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
БЗД	Багийн засаг дарга
ХШУДАХ	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт аймгийн Аудитын газраас 2017 онд нийтгүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу аймгийн ИТХурлын захиалгыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын баталсан ААГ-НА/2017/02-НА төлөвлөгөөг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 2016 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд аудитыг хийж гүйцэтгэв.

1. Аудитын зорилт:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 2016 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг аймгийн ИТХуралд болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Үүнд:

- ХЭДСангийн орлогыг хууль, журамд зааснаар бодитой төлөвлөж, бүрдүүлсэн эсэх;
- ХЭДСангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан журмын дагуу зарцуулсан эсэх;
- ХЭДСангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх.

2. Аудитын хамрах хүрээ:

Аудитыг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын ажлын баримтад тулгуурлан 2016 оны ХЭДСанд улс, орон нутгийн төсвөөс хуваарилж олгосон шилжүүлэг, бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаар тэдний гүйцэтгэсэн ажлын тайлан, мэдээ, судалгаа, анхан шатны болон НББүртгэлийн баримт, бусад холбогдох материалд тулгуурлан гүйцэтгэв.

3. Аудитад хэрэглэсэн арга зүй:

Аудитыг АДБОУС 100, 400, 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашигласан болно.

4. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль

- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолыг 1-р хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”
- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолыг 2-р хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох журам”
- Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2016 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүд батлах тухай”
- “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Хөдөлмөрийн сайдын 2016 оны а/06 тоот тушаал
- “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх удирдамж батлах тухай” Хөдөлмөрийн сайдын 2016 оны а/12 тоот тушаал
- Аймгийн ИТХурал, ЗД-аас гаргасан шийдвэр, бусад холбогдох дүрэм, журам.

5. Аудитын стандартын талаарх мэдэгдэл:

Энэхүү аудитыг аймгийн Аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын баталсан аудитын ААГ-НА/2017/02-НА төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж ажиллав. Төрийн хяналт, шалгалтын стандарт, аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох, нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

6. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитын явцыг аймгийн Аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Л.Ламаачин хянан удирдаж, аудитын менежер Ц.Отгонням аудитын стандарт, арга зүйн дагуу хяналт тавьж, ахлах аудитор Д.Гансүх, аудитор П.Хорлоосүрэн, шинжээч Θ.Ринчинмядаг нар 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдруүдэд хийж гүйцэтгэв.

7. Ерөнхий мэдээлэл:

1. Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 16-ны № 09 тогтоолоор: “Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр”, “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх, үйлчилгээний төсөл”-ийг нэмэлт өөрчлөлтөөр оруулж, 2016 онд хэрэгжүүлэхээр шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангаж ажилласан.

2. Хөдөлмөрийн сайдын 2016 оны 01 дүгээр сарын 12-ны №а/06 тушаалаар: “Үйлдвэрлэл дээрх сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ”, “Мэргэжлийн болон давтан, явууллын сургалтын нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардлын жишиг хэмжээ”-г баталсан ба зардлын жишиг хэмжээг үйл ажиллагаандaa мөрдсөн байна.

3. Хөдөлмөрийн сайдын 2016 оны 01 дүгээр сарын 18-ны №а/12 тушаалаар: “Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж”, “Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж”,

“Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж”, “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж”, “Ахмад мэргэжилтний зөвлөх, үйлчилгээний төслийг хэрэгжүүлэх удирдамж”-ийг тус тус баталж, орон нутагт удирдамжийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулжээ.

4. Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2012 оны 01 дүгээр сарын 31-ны №01 тогтоолоор аймаг, нийслэл, дүүргийн салбар зөвлөлийн дүрмийг баталсан.

Дүрмээр хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн Зөвлөлийн эрх, үүрэг, түүний удирдлага зохион байгуулалт, санхүүжилттэй холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд зөвлөлийг ЗДОрлогч удирдах ба ажилтны хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагын төлөөлөл 3 хүн, ажил олгогчийн хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагын төлөөлөл 3 хүн байх ба улиралд 1-ээс доошгүй удаа хуралдах, 75.0 хувиас дээш ирцтэй байхаар заажээ.

Аудитаар 303.8 сая төгрөгийн үр өгөөж тооцож, 296.5 сая төгрөгийн акт, 7.3 сая төгрөгийн албан шаардлагыг аймгийн ХХҮГазарт хүргүүлж байна.

Өвөрхангай аймгийн ХЭДСангийн 2016 оны орлогын бүрдүүлэлт, зарим хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн хангалтгүй байна.

БҮЛЭГ-1

ХЭДСангийн үйл ажиллагааны орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт хангалтгүй байна.

1.1. Сангийн эх үүсвэрийг хууль, тогтоомжтой уялдуулан төлөвлөөгүй байна.¹²

Хөдөлмөрийн Сайдын 2016 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А/106 тоот тушаалаар тус аймагт ХЭДСангаас хуваарилсан санхүүжилт 1109.8 сая төгрөг, ХБИргэн ажиллуулаагүйн төлбөр 10.0 сая төгрөг, нийтдээ sangийн орлогын эх үүсвэрийг 1119.8 сая төгрөгөөр төлөвлөж, баталсан байна.

¹ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:
22.1.1.улсын төсвээс хуваарилсан хөрөнгө;
22.1.2.орон нутгийн төсвээс хуваарилсан хөрөнгө;
22.1.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хув;
22.1.4.гадаадын иргээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр;
22.1.5.гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл;
22.1.6.гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламж;
22.1.7.хөгжлийн бэрхшээлтэй буюу одий хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр;
22.1.8.бусад эх үүсвэр.

² Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллага, Хурлын болон Засаг даргын бүрэн эрх 30.1.16.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг бүрдүүлэх, хөрөнгийн хуваарилалтын төслийг боловсруулах, батлуулах, хөрөнгийг баталсан хуваарийн дагуу зарцуулах, хяналт тавих, тайлгах;

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/77 тоот тушаалаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн хуваарийг шинэчлэн ХЭДСангаас хуваарилсан санхүүжилтийг 885.1 сая төгрөгөөр тодотгон баталжээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд сангийн эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө байхаар заасан ч орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилдаггүй байна. /ХЭДСангийн журамд: “Дэд санд аймаг, нийслэл, дүүргийн төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь тухайн төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй байна” гэж заасан байдал/

Монгол улсын ЗГ-ын 2009 оны 01 дүгээр сарын 28-ны 26 тоот тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээ”-г аймгуудад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 30 хувиар сар бүр төлөхөөр тогтоосон байна.

Үүний дагуу хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийн орлогыг Уянга сумын АУМ-Алт ХХК, Аймгийн ЭБЦТСтанц, Буд-Ундром ХХК, Дэлгэрэх хүнс ХХК, Соёмбо цогцолбор сургууль зэрэг 5 байгууллага, аж ахуйн нэгжээс нийтдээ 6.5 сая төгрөгийг аймгийн ХЭДСанд төвлөрүүлсэн байна.

ХЭДСанд Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй 97 байгууллага, 5 аж ахуйн нэгжүүдээс төвлөрүүлбэл зохих 105.4 сая төгрөгийн 6.1 хувийг санд оруулсан ба 92 байгууллага, аж ахуйн нэгжийн 98.9 сая төгрөгийг ХЭДСанд төвлөрүүлээгүй байна.

Аймгийн ХЭДСангийн эх үүсвэрийг төлөвлөхдөө орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилаагүй, хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийн орлогыг бүрэн тусгаж төлөвлөгүй байна. Тиймээс ХЭДСангийн орлогыг бүрэн төлөвлөх, төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах шаардлага байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ-ын дарга А.Ишдорж, Засаг дарга Г.Ганболд, Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга С.Ундрах нарт:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, журмын дагуу орон нутгийн төсвөөс аймгийн ХЭДСанд төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй хөрөнгийг хуваарилан төвлөрүүлж байх.
- Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийн орлогыг бүрэн тусгахад анхаарах. Энэ талаар хууль, журмыг боловсронгуй болгох асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад хандаж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.

1.2. Сангийн орлогыг хуулийн дагуу бүрэн бүрдүүлээгүй, нөөц боломжоо дайчлан ажиллаагүй байна.

Аймгийн ХЭДСангийн 2016 оны орлого бүрдүүлэлтээр төв сангаас 888.7 сая төгрөг, нэр данс зөрүү орлого 0.3 сая төгрөг, ХБИргэн ажиллуулаагүйн төлбөр 6.5 сая төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны орлого /урьд оны актын төлбөр/ 0.8 сая төгрөг, хөтөлбөрийн эргэн төлөлтөөр 202.1 сая төгрөг, нийтдээ 1098.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Аймгийн ХЭДСангийн 2016 оны орлогын бүрдүүлэлт /мян.төгрөг/ Хүснэгт№01

Д/д	Сангийн орлогын эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Орон нутгийн төсвөөс хуваарилсан санхүүжилт	0	0	0
2	ХЭДСангаас хуваарилсан санхүүжилт	1109826.0	888764.7	221061.3
3	Нэр данс зөрүүгийн орлого	0.0	300.0	-300
4	ХБИргэн ажиллуулаагүйн төлбөр	10000.0	6566.4	3433.6
5	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны орлого	0.0	815.3	-815.3
6	Эргэн төлөлтөөс орсон орлого	0.0	202117.2	-202117
	Дүн	1119826.0	1098563.6	21262.4

Урд онуудад хийсэн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын дагуу төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах, ажиллуулаагүй нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөрийг авах талаар анхааруулж, зөвлөдөг боловч байгууллага, аж ахуйн нэгжийн төсөвт зардал нь суугдаагүй, хөрөнгө зардалгүй зэрэг шалтгаанаар тодорхой үр дүн гарахгүй байна.

Мөн санд орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилаагүй, хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийн орлогыг төвлөрүүлэх талаар нөөц боломжоо бүрэн дайчилж ажиллаагүй байна.

Аймгийн ХЭДСангийн 2016 оны батлагдсан төсөв /мян.төгрөг/ Хүснэгт№02

№	Үзүүлэлт	Анх батлагдсан	Тодотгосон	Зөрүү	Хувь
1	Ажилд зуучлах	6000.0	2879.0	3121.0	48.0
2	Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр	229400.0	188484.9	40915.1	82.2
3	Хөдөлмөр эрхлэлтийг ур чадвар олгох, иажлын байрыг дэмжих хөтөлбөр	140150.0	65306.0	74844.0	46.6
4	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	109730.0	78930.0	30800.0	71.9
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	72416.0	53700.0	18716.0	74.2
6	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	322000.0	350740.9	-28740.9	108.9
7	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр	132000.0	88252.1	43747.9	66.9

8	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр	18600.0	8718.1	9881.9	46.9
9	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	16000.0	5600.0	10400.0	35.0
10	Хүүгийн хөнгөлөлт	4080.0		4080.0	0.0
11	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах	3000.0	2593.4	406.6	86.4
12	Хөдөлмөрийн салбарын ажилтнуудын сургалт	5950.0	5391.7	558.3	90.6
13	Бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах	15000.0	6729.0	8271.0	44.9
14	Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	9000.0	7803.4	1196.6	86.7
15	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл	4000.0	1592.8	2407.2	39.8
16	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрх	6500.0	2917.1	3582.9	44.9
17	Хөтөлбөр төслийн хяналт үнэлгээ	12000.0	11952.1	47.9	99.6
18	Гарын авлага хэвлэмэл материал	4000.0	3570.0	430.0	89.3
Дүн		1109826.0	885160.5	224665.5	79.8

ХЭДСангийн 2016 оны санхүүжилт оны эхэнд батлагдсан төсвөөс 224.6 сая төгрөгөөр буюу 20.2 хувиар буурсан байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, хalamж үйлчилгээний газрын дарга С.Ундрех-д:

- Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийн орлогыг санд төвлөрүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулах.

БҮЛЭГ-2

Аймгийн ХЭДСангийн хөрөнгө хууль, журмын дагуу зарцуулагдаж, төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа ч зарим хөтөлбөр тодорхой үр дүнд хүрээгүй байна.

2.1. Аймгийн ХЭДС-ийн хөрөнгийг хууль, журмын дагуу хуваарилан зарцуулсан ч хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах явдал гарсаар байна.³⁴

³ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг дараах төсөл, хөтөлбөрийн хэлбэрээр хэрэгжүүлнэ:

6.3.1.хөдөлмөрт бэлтгэх;
6.3.2.хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;
6.3.3.малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих;
6.3.4.ажил олгогчийг дэмжих;
6.3.5.нийтийг хамарсан ажил зохион байгуулах;
6.3.6.ажил олоход хүндэтгэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

⁴ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг дор дурдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулна:

23.1.1.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;
23.1.2.ажилд зуучлах;
23.1.3.хөдөлмөрт бэлтгэх;
23.1.4.хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;

Аймгийн ХЭДСангийн 2016 оны хөрөнгөөр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийтийг хамарсан ажил, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг хадгалах, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг дэмжих зэрэгт нийтдээ 885.1 сая төгрөгийг ХЭДТухай хуулийн дагуу хуваарилан төлөвлөж, зарцуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөлөөс хөтөлбөрүүдийн шалгуур, чиглэл, квотыг тогтоосны дагуу сумдад чиглэл өгч сумдын төсөл сонгон шалгаруулах комиссын болон Амьжирааг дэмжих зөвлөлийн хурлаас дэмжигдсэн төсөл, хөтөлбөрүүдийг тус газрын төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгээр нягтлан хэлэлцэж, төсөл хөтөлбөрүүдийг шалгаруулдаг байна.

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөл 2016 оны 02 дугаар сарын 04-нд хуралдаж: Хөдөлмөрийн хэлтсийн 2015 оны үйл ажиллагааны тайлан, 2016 онд хэрэгжих хөтөлбөрүүдийн танилцуулга, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 2015 оны тайлан, Залуучуудын хөгжлийг дэмжих жилийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд хийгдэх ажлуудыг төлөвлөх асуудлыг хэлэлцсэн байна.

Тус хурлаар салбар зөвлөлийн гишүүн 9 хүнээс 6 хүн нь хуралдаж, хурлын ирц 66.6 хувьтай байгаа нь дүрэмд заасан 75.0 хувиас дээш ирцтэй байх шаардлагыг хангаагүй байна. Мөн аймгийн салбар зөвлөл 2016 оны 04 дүгээр сарын 13-нд хуралдаж: ХЭДС-ийн 2016 оны төсөв, Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулахад шалгуур, чиглэл гаргах, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн малжуулах арга хэмжээг зохион байгуулах тухай асуудлыг авч хэлэлцээд:

- Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд улирлын чанартай газар тариалан, хүнсний ногоо тариалах төслүүдийг тус хөтөлбөрийн 3.6-д заасан бүлгийн зохин байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд хамруулах, блок, тоосго, дугуй засвар, вакум цонх, худалдаа, үсчин, гоо сайхан, гар урлал чиглэлийн төслүүдийг зах зээл бага гэж үзээд дэмжихгүй байх, оёдлын чиглэлээр 15, мужааны 8 төсөл дэмжих.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд гар урлал, оёдлын чиглэл төслийг 50.0 хувь дэмжих.
- Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд малжуулах арга хэмжээг зохион байгуулахад 78 малчин өрхийг 4.0 сая төгрөгөөр малжуулахаар тус тус шийдвэрлэсэн байна.

-
- 23.1.5.ажил олгогчийг дэмжих;
 - 23.1.6.нийтийг хамарсан ажил зохион байгуулах;
 - 23.1.7.малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих;
 - 23.1.8.ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
 - 23.1.9.хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах, шинчлэх;
 - 23.1.10.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилтийг хянах, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, сурталчилгаа явуулах, гарын авлагыг, хэвлэлмэл материал бэлтгэж хэвлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дунд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэх;
 - 23.1.11.хууль тогтоомжид заасан, түүнчлэн Засгийн газрын болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлсон бусад хөтөлбөр, төслийг санхүүжүүлэх.
 - 23.1.12.сумын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалтаар сүм хөгжүүлэх санд хөрөнгө хуваарилах.

Дүрэмд зааснаар улиралд 1-ээс доошгүй удаа хуралдах гэж заасан боловч эхний 2 улиралд хуралдаж, сүүлийн улиралд хуралдаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөлийн дарга О.Батжаргал-д:

- Салбар зөвлөлийн хуралдааныг дүрмийн дагуу улирал бүр 75.0 хувиас доошгүй ирцтэйгээр хуралдуулж, дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Аймгийн ХЭДСангийн 2016 оны хөрөнгийн зарцуулалтаас үзэхэд:

- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах чиглэлээр 1320 иргэнд 9.0 сая төгрөг.
- Ажилд зуучлахад 960 иргэнд 2.9 сая төгрөг.
- Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөрт 519 иргэн, аж ахуйн нэгжид 188.5 сая төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 169 иргэнийг хамруулж 53.7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг.
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 69 иргэн хамрагдаж 78.9 сая төгрөг.
- Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 86 өрх хамрагдаж 350.7 сая төгрөг.
- Нийтийг хамарсан ажилд 479 иргэн хамрагдаж 88.2 сая төгрөг
- Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг хадгалах нөхцөлд 238 иргэн 65.3 сая төгрөг
- Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөрт 28 иргэнд 5.6 сая төгрөг
- Аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардалд 1.6 сая төгрөг.
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2.6 сая төгрөг.
- Хөдөлмөрийн салбарын ажилчдын сургалтад 5.4 сая төгрөг
- Гарын авлага материал бэлдэх хэвлүүлэхэд 3.5 сая төгрөг.
- Сурталчилгаа, нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах ажлуудад 7.8 сая төгрөг.
- Хяналт үнэлгээний зардалд 11.9 сая төгрөг
- Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилтэд 0.9 сая төгрөг
- Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилт 2.9 сая төгрөг
- Мэдээлэл сүлжээний зардалд 6.7 сая төгрөг, нийтдээ 885.5 сая төгрөгийг аймгийн ХЭДСангаас зарцуулжээ.

Аймгийн ХЭДСангийн 2016 оны үлдэгдэл 213.1 сая төгрөгийг төв санд буцаан төвлөрүүлсэн байна.

ХЭДСангийн санхүүжилтийг сүүлийн 3 жилээр зэрэгцүүлбэл /мян.төгрөг/


Хүснэгт №03

№	Үзүүлэлтүүд	2014 он		2015 он		2016 он	
		Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах	2134	12000.0	2023	1542.7	1320	9018.1
2	Ажилд зуучлах	2453	9925.5	1505	5921.3	960	2879.0

3	Хөдөлмөрт бэлтгэх	110	9578.7	158	243000.0	28	5600.0
4	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах	132	46560.0	180	10990.4	238	65306.0
5	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ	20	45803.2	48	118476.0		
7	Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	416	88904.3	224	46996.3	519	188484.0
8	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	50	239973.5	202	885750.0	86	350740.9
9	Эзэнтэй монгол хөтөлбөр	780	190959.9	1037	196498.1	479	88252.1
10	ХБИргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	58	50080.8	48	77304.0	169	53700.0
11	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	689	137800.0	105	22022.4	69	78930.0
12	40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	139	53405.0	86	39168.5		0.0
13	Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл	148	44400.0		933.9		0.0
14	Ажилтнуудын чадавхи бэхжүүлэх	19	8263.2		6064.9		5391.7
15	Аймгийн салбар зөвлөл		3663.0		2938.5		1592.8
16	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр		3455.5		1747.3		2593.4
17	Гарын авлага матриал бэлдэх хэвлүүлэх		4350.0		4500.0		3570.0
18	Сурталчилгаа, нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах		130207.7		15482.7		7803.4
19	Хөтөлбөр, төслийн хяналт, шинжилгээ		21853.6		25786.7		11952.1
20	Мэдээлэл сүлжээний зардал		1090.0		20666.6		6729.0
21	Засгийн газар, болон бусад шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр, төслийн санхүүжилт				39991.3		2917.0
Дүн		7148	1102273.9	5616	1765781.6	3868	885459.5

ХЭДСангийн санхүүжилтийг сүүлийн 3 жилээр зэрэгцүүлбэл /мян.төгрөг/ График №01

Сангийн орлогын бүрдүүлэлтийг сүүлийн 3 жилээр



ХЭДСангийн хөрөнгийн санхүүжилт, зарцуулалт 2014 онд 1102.3 сая төгрөг, 2015 онд 1765.8 сая төгрөг болж урд оноос 663.5 сая төгрөгөөр нэмэгдсэн бол 2016 онд 885.4 сая төгрөг болж урд оноос 880.4 сая төгрөг буюу 50.1 хувиар буурсан байна.

Аудитаар ажил олгогчийн дэмжлэгээс төрийн өмчийн оропдоотой Төрийн банкинд 1 хүний 2.3 төгрөгийг олгосон зөрчил илэрсэн.

Хоолны зардлаас 4.4 сая төгрөгийг Ерөнхий менежерийн тушаал гаргаагүй анхан шатны баримтын бүрдэл дутуу зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээж авсан ажилтан хариуцна”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн.

Хяналт шалгалтын зардлаас шатахуунд 64.9 хувь буюу 7.7 сая төгрөгийг зарцуулж анхан шатны баримтын бүрдэлгүй байна.

Гэрээний төлбөр болох 2.9 сая төгрөгийг Төгөлдөр-Өв ХХК, Дөлгөөн соёмбо ХХК, Хас-Өрлөг ТББ-дад шилжүүлсэн боловч гэрээ болон бусад бичиг баримт байхгүй байв.

ЗӨВЛӨМЖ

**Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга
С.Ундрас-д:**

- Хөтөлбөр болон сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, анхан шатны баримт бүрдлийг хангаж ажиллах.

2.2. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа ч зарим хөтөлбөр тодорхой үр дүнд хүрээгүй байна.⁵

⁵ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд:

10 дугаар зүйл.Хөдөлмөрт бэлтгэх

11 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах

12 дугаар зүйл.Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих

1. Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөрийн хүрээнд:

Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ, ажилд зуучлах үйлчилгээг зохион байгуулахдаа ажил олоход хүндрэлтэй иргэнийг хамруулах бөгөөд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээлэл өгөх, ажлын байр, үйлдвэрлэлтэй танилцах, хүнтэй харилцах, амжилтын түүх солилцох, өндөр ур чадвар бүхий ахмад зөвлөхүүдтэй уулзалт зохион байгуулах, өөрийгөө ойлгуулах суурь чадвар эзэмшүүлэх, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн дэг журам, аюулгүй ажиллагааны анхан шатны мэдлэг олгох ба арга хэмжээний үргэлжлэх хугацаа нь 3-5 ажлын өдөр байхаар журам гаргасан байна.



Зураг 1: Мэргэжил олгох сургалтын явц

Мэргэжлийн болон явуулын, үйлдвэр дээрх сургалтын хэлбэрээр ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй 229 иргэнийг тогооч, оёдол эсгүүрчин, талх нарийн боовч, засал чимэглэл, ногоочин, цэцэрлэгийн туслах багш, үсчин мэргэжлээр мэргэжил олгох сургалтад хамруулж, 42.2 сая төгрөгийг зарцуулжээ.

Ажил олгогчийг дэмжих арга хэмжээг зохион байгуулахдаа ажилгүй иргэнийг ажилд авч 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод

хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг ажлын байраар хангагдсан иргэн бүрээр тооцож нэг удаа олгох, асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг үндсэн ажилтнаар авч 12 сараас дээш хугацаагаар үргэлжлүүлэн ажиллуулж байвал нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг ажил олгогчид нэг удаа олгохоор заасан.

Ажил олгогчийг дэмжих арга хэмжээний хүрээнд: 2015 онд дэмжлэгт хамрагдахаар гэрээ байгуулсан ажил олгогч байгууллагуудаас ажил олгогчийн дэмжлэг авах нөхцөл бүрдсэн иргэнийг тогтвортой суурьшилтай ажиллуулж байгаа Тэргүүн-Үндрага ХХК, Монгол засвар ХХК, Бумбат Наран ХХК, Мон-Ургамал ХХК, Баянхайрхан баялаг ХХК, Зөвлөн сувд ХХК, Арцат ХХК, Төрийн банк, Лхагва баасан цэцэрлэг зэрэг 9 аж ахуй нэгж байгууллагад 23.0 сая төгрөгийн урамшууллыг олгосон байна.

2. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

ЕБСургуулийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр ганцаарчилсан зөвлөгөөнд мэргэжил сонголтын чиглэлээр ЕБСургуулийн 10 сурагч, MCYTөвийн төгсөх курсын 18 суралцагч хамрагдсан ба “Ажил мэргэжлийн мэдээллийн төв”-өөр дамжуулан ЕБС-ийн суралцагчдын эцэг эх, нийгмийн ажилтан, багш нарт зориулсан өдөрлөг, арга хэмжээ зохион байгуулж 728 иргэн оролцжээ.

Ажилгүй иргэдэд чиг баримжаа олгох чиглэлээр зорилтот бүлгийн нийт 690 иргэн хамрагдсаны ажил хайгч 519, ажил олоход хүндрэлтэй 17, ажилгүйдэпд өртөж болзошгүй

13 дугаар зүйл.Ажил олгогчийг дэмжих

14 дүгээр зүйл.Нийтийг хамарсан ажил зохион байгуулах

15 дугаар зүйл.Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

154 иргэн хандан мэргэжлийн боловсрол, хөдөлмөр эрхлэлт, мэргэжил сонголтын талаар мэдээлэл, зөвлөгөө өгсөн байна.

Ганцаарчилсан зөвлөгөө мэдээллээр 510 иргэн, бүлгийн сургалт зөвлөгөөгөөр 180 иргэнд үйлчилгээ үзүүлжээ.

3. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөрийн хүрээнд:



Зураг 2: Ахмад мэргэжилтэн иргэдэд сургалт, зөвлөгөө өгөх явц

28 ахмад настан хамруулж 5.6 сая төгрөг санхүүжилтээр 1863 иргэнд боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, бусад чиглэлүүдээр сургалт, зөвлөгөө өгчээ.

Энэ нь нэг талаас ахмадуудын орлого нэмэгдэх, нөгөө талаас орон нутагт хэрэгцээтэй байгаа сургалт, зөвлөгөөг өгч хүүхэд залуучуудад мэдлэг боловсрол, амьдрах ухаан, дадлага туршлагаасаа хуваалцаж байгаа үр дүнтэй ажил болсон байна.

4. Нийтийг хамарсан ажлын хөтөлбөрийн хүрээнд: Байгалийн гамшиг, давагдашгүй хүчний шинжтэй бусад нөхцөл байдлын улмаас үүссэн хор уршгийг арилгах, нөхөн сэргээх, нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайг сайжруулах, тохижилт хийх, хог хаягдалгүй байлгах, сургууль, цэцэрлэгийн ойролцоо гэрлэн дохио, гарцаар зам гарахыг зохицуулах, байгаль орчинг хамгаалах, ой цэвэрлэх, мод тарих, голын ай сав, үер усны даланг цэвэрлэх, байгуулах, засварлах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулахаар журамд заасан.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд 16 суманд 28 төсөл хэрэгжүүлж, нийтийн эзэмшлийн талбай засах, тохижуулах, хог хаягдалгүй байлгах, голын ай савыг цэвэрлэх, ногоон байгууламж тохижуулах, зүлэг, мод бут тарих, мэрэгчтэй тэмцэх зэрэг ажлуудыг хийлгэн 646 ажил хайгч иргэнийг түр ажлын байраар ханган, ажиллах хүчний зардалд 88.2 сая төгрөгийг зарцуулжээ.



Зураг 3: Нийтийн эзэмшлийн талбай тохижуулж буй явц

Нийтийг хамарсан ажлын баримтад: Төлбөрийн хүсэлт, цалингийн цэс, сумын ЗД-ын албан тоот, төсөл, сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлын тэмдэглэл, ирцийн бүртгэл, нийтийг хамарсан ажлын гэрээ, цагийн бүртгэл, хөдөлмөр хамгааллын хувцас тараасан жагсаалт, хөдөлмөр эрхлэлтийн ажилтан, ажиллагдын хооронд байгуулсан хөлсөөр ажиллах гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбар, ажлын гүйцэтгэл хүлээн авсан тэмдэглэл, тайлан, ажлын гүйцэтгэлийг зургаар баталгаажуулсан баримтуудыг үдсэн байна.

Аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Нийтийг хамарсан ажлын хүрээнд Өлзийт суманд хийгдсэн 1.7 сая төгрөгийн “Сангийн далайн тойром харваа-нд зориулж Сангийн далайн зүүн талд Үндэсний шагайн харваан хөшөө барих” ажлыг зориулалт бус ажилд зарцуулсан байна.
- Мөн Өлзийт суманд хийгдсэн ажлын хөлс 3.4 сая төгрөгийн “Яргайтын сүм хийгдсэн Хайлангийн булаг хаших, сүмийн орчны засварлахад зарцуулсан байна.
- Хайрхандулаан, Тарагт, Хархорин, Зүүнбаян-Улаан сумдуудын ажилласан иргэдийн иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсаргаагүй байна.

5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих хөтөлбөрийн талаар: Хөтөлбөрт хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй иргэн дараах нөхцөл шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийн хугацаа нь хүчинтэй тухайн иргэний биеийн байдал нь ажил хөдөлмөр эрхэлж, төслөө хэрэгжүүлэх боломжтой байх;
- Албан ёсоор оршин суугаа харьяллынх дагуу аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлж, санхүүгийн дэмжлэгт хамрагдах өөрийн хүсэлтээ бичгээр илэрхийлсэн байх;
- Хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр өрхийн үйлдвэрлэл, аж ахуй бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд хэрэгжих үндэслэлтэй бизнесийн санаа, сонирхол, үр ашиг, орлого нэмэгдүүлэх тооцоо судалгаатай төсөл, үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсвийн саналыг боловсруулсан байх;
- Төслийг нөхөрлөл, хоршоо, бүлгийн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх бол гишүүд, оролцогчдын үүрэг, хариуцлага, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг бичгээр тодорхойлсон байхаар заасан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих хөтөлбөрийг зохион байгуулах хуралдааныг 2016 оны 03 дугаар сарын 15-ны №04/02 тоот тэмдэглэлээр ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүд нийтдээ 5 хүн оролцож 85 төслийг хэлэлцээд нийтдээ 67 төслийн 50.0 сая төгрөгийг хөтөлбөрийн санхүүжилтэд зарцуулахаар шийдвэрлэсэн байна.



Зураг 4: ХБИргэнийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэний ажлын явц

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байнгын ажлын байр бий болгох зориулалтаар 67 иргэнд 50.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. Хөтөлбөрийн санхүүжилтийг олгоходоо төлбөрийн хүсэлт, ХБИ-ийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн жагсаалт, хяналтын хуудас, нэхэмжлэх, санхүүгийн дэмжлэг олгох гэрээ, иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон акт, өргөдөл, сургалтын гэрчилгээ, иргэний үнэмлэхийн хуулбар, БЗД-ын тодорхойлолт, төсөл, санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдах иргэний төслийн анхан шатны судалгааны маягт, татвар төлсөн тасалбар зэрэг баримтуудыг хавсаргажээ.

ХБИ-ний аж ахуй эрхлэлтийн сургалтаар: сургалт зохион байгуулах гэрээ, нэхэмжлэх, төлбөрийн хүсэлт, хүсэлт тоот, мэргэжлийн сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлага хангасан гэрчилгээ, батламжлах гэрчилгээ, сургалтын танилцуулга, сургалтын загвар, тайлан, сургалтын зардлын тооцоо, сургалтын хөтөлбөр, сургалтад хамрагдсан иргэдийн нэrsийн жагсаалт, ирцийн бүртгэл, сургалтын үнэлгээ, сургалтад оролцогчийн анкет, иргэний үнэмлэхийн хуулбар зэрэг баримтыг бүрдүүлжээ.

Сургалтыг Дэлгэрэх бүтээмж ТББ-аас “Бизнесээ хөгжүүл” сургалт, ОСТА ХХК сургалтын төвийн “Бизнес эхлэх, хөгжүүлэх сургалт” тус тус явуулж, 2.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

6. Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөрийн талаар:

Хөтөлбөрийн хүрээнд: Жижиг зээл олгох, санхүүгийн дэмжлэг олгох, аж ахуй эрхлэлтийн сургалт явуулах, борлуулалтын болон ажлын байрны дэмжлэг үзүүлэх, бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах ажлуудыг хийхээр заасан байна.

Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулахдаа Аж ахуй эрхлэх, бичил бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй хөдөлмөрийн насын хорих ангиас суллагдсан иргэн, 35 болон түүнээс дээш насын иргэнд 3.0 сая хүртэл төгрөгийн гарааны санхүүгийн дэмжлэгийг олгоно.

Аж ахуй эрхлэлтийн сургалтын үргэлжлэх хугацаа ажлын 3 болон 5 хоног байх бөгөөд 3 хоногийн сургалт нь 21-ээс, 5 хоногийн сургалт нь 36-гаас доошгүй цагийн хөтөлбөртэй байна.

Үйлдвэрлэлийн ажлын байр түрээслэн үйл ажиллагаа тасралтгүй 12 сараас дээш хугацаагаар эрхэлсэн хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хорооог холбогдох баримт бичиг, түрээсийн гэрээг үндэслэн нөхцөл байдлыг газар дээр нь тодорхойлсны үндсэн дээр ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг нөхөн олгоно.

Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй иргэдийг сонгон шалгаруулж, тодорхой төлөвлөгөөний дагуу хүнсний ногоо тариалах арга барилд сурган бүлгийн зохион байгуулалтад оруулж ажиллуулна гэж журамд заажээ.

Аж ахуй, бичил бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй хөдөлмөрийн насын хорих ангиас суллагдсан иргэн, 35 болон түүнээс дээш насын 144 иргэнд 135.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. /1 иргэнд 0.5-1.0 сая төгрөг, 1.5-2.5 сая төгрөг/ Жижиг зээл 8 хүнд 39.0 сая төгрөгийг олгосон.

Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 11 сумын 30 бүлийн 150 ажил хайгч иргэнийг түр ажлын байраар ханган 43.8 сая төгрөгийг зарцуулжээ.

Аж ахуй, бичил бизнес эрхлэгч 225 иргэнийг “Дэлгэрэх бүтээмж”, “ОСТА” сургалтын байгууллагатай гэрээний үндсэн дээр аж ахуй эрхлэлтийн бизнесээ эхэл сургалтад хамруулж 6.6 сая төгрөгийг зарцуулсан. Нийтдээ тус хөтөлбөрт 519 иргэн хамрагдаж 245.0 сая төгрөгийг зарцуулсан байна.



Зураг 5: Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан төслийн хэрэгжилтийн байдал

Санхүүгийн дэмжлэгийг нэг хүнд 0.5-1.0 сая төгрөгөөр олгож байгаа нь дэмжлэг болж төдийлөн чадахгүй байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 2015 онд 158 иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршооны төслийг сонгон шалгаруулж, нийтдээ 243.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон. Үүний 50.0 хувь болох 121.5 сая төгрөгийг 2016-2017 онуудад буцаан санд төвлөрүүлэхээр гэрээ байгуулж, төлөлтийн хуваарь хийсэн байна. Үүний эргэн төлөлтийг үзэхэд 96.2 сая төгрөгийн дутуу төлөлттэй байгаад акт тогтоож байна.

Санхүүгийн дэмжлэгийг Өргөдөл, төсөл, Амьжиргааг дэмжих зөвлөлийн тэмдэглэл, санхүүгийн дэмжлэг олгох гэрээ, иргэнийн үнэмлэхийн хуулбар, нэхэмжлэх, татвар төлсөн баримт, БЗД-ын тодорхойлолт зэрэг баримтыг үндэслэн олгосон ба баримт бүрдэл сайн байв.

7. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн талаар: 15-25 хүртэлх наасны, их дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчид, мөн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын 2014 оноос хойших төгсөгчид, тэдгээрийн бүлэг энэхүү хөтөлбөрт хамруулахаар журамласан.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 15 суманд МСҮТ-ийн 38 төгсөгчид хувиараа хөдөлмөр эрхэлж, орлого олохыг дэмжих зорилгоор нэг төгсөгчид 2.0 сая төгрөгөөр тооцож, нийтдээ 78.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг төгсөгчдийн ажлын байрыг бий болгоход зарцуулсан байна.



Зураг 6: Хөтөлбөрт хамрагдсан МСҮТөвийн төгсөгчийн ажлын явц

Хувиараа хөдөлмөр эрхлэгч 31 төгсөгчдөд “Дэлгэрэх бүтээмж” сургалтын байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр аж ахуй эрхлэлтийн бизнесээ эхэл сургалтад хамруулж 0.9 сая төгрөгийг зарцуулжээ.

Аудитаар: Зарим төслийн гэрээнд зааснаас өөр нэр, өөр зориулалт бүхий төслийг хавсаргасан, төслийн тооцоопол үндэслэл муу байсан зэрэг зөрчил гарсан байна.

8. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн талаар: 35 хүртэлх наасны 2-оос доошгүй гишүүнтэй 100 хүртэл, 100-150 хүртэл толгой малтай малчин өрхийг энэхүү хөтөлбөрт хамруулахаар заасан.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр нь нийт 16 суманд 35 хүртэлх наасны 86 малчинд 344.0 сая төгрөгийн 8102 тооны бог мал худалдаж авч өгчээ.

Аж ахуй эрхлэх болон туршлага солилцох уулзалтад 6740.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэхүү хөтөлбөрийн хөрөнгийн эргэн төлөгдөх хугацаа нь 2014 онд 3 жил байсан ба Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/12 дугаар тушаалаар эргэн төлөх хугацааг 2 жил болгосон байна.

Үүнтэй холбоотой 2014-2016 онд дэмжигдсэн 338 төслүүдийн Малчин өрхийг малжуулах арга хэмжээний 3 талт гэрээнд хавсаргасан эргэн төлөлтийн батлагдсан хуваарьтай тулган үзсэн болно.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2014-2016 онд хамрагдсан малчдын эргэн төлөлт /мян.төгрөг/

Хүснэгт №04

Тайлантын он	Малчин өрхийн нийт эргэн төлөлт		
	Төлөх дүн	Төлөгдсөн дүн	Төлөгдөөгүй дүн
2015	135718.8	55325.5	80393.3
2016	304437.5	184475.4	119962.1
Нийт дүн			200355.4

Аудитаар: Мал тооллогын А маягтыг гарын үсэг, тамга, тэмдгээр бүрэн баталгаажуулах шаардлагатай байна. Эргэн төлөлтийн дутууд акт тавигдсан болно.

Аймгийн хүн ам өсөхийн хэрээр ажилгүйчүүдийн тоо нэмэгдсээр байна. Сүүлийн 3-н жилийн статистик мэдээллээр ажилгүйчүүдийн тоо 2014 онд 1907 хүн, 2015 онд 1945 хүн, 2016 онд 2482 хүн ажил идэвхтэй хайж, ажилгүйдлийн түвшин 3.4-3.6 хувьтай гэсэн статистик бүртгэл гарчээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүжилтийн эх үүсвэр дутмаг, түүний дотор дэмжлэг хүссэн хүмүүст олгож буй хөрөнгийн дүн бага байгаа нь ажлын байрыг нэмэгдүүлэх хөшүүрэг болж төдийлөн чадахгүй байна.

Хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэг, түүний эргэн төлөлтийн байдлаас үзэхэд гэрээ, хуваарийн дагуу эргэн төлөлт хугацаандаа хийгдээгүй, зарим нь эргэн төлөгдөх эсэх нь эргэлзээтэй байгаа нь ажлын байрны дэмжлэг гэхээсээ илүүтэй халамжийн шинж чанартай болсон байдал ажиглагдсан болно.

ЗӨВЛӨМЖ

**Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга
С.Ундрас-д:**

- Хөтөлбөрийн хөрөнгийг ажлын байрыг тогтвортой нэмэгдүүлэхэд чиглүүлж, иргэдэд бодитой дэмжлэг болохуйцаар зохион байгуулах.



Зураг 7: Хөтөлбөрт хамрагдсан малчин өрхийн мал худалдан авч, хүлээлцэж буй байдал

БҮЛЭГ-3

Сангийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт хийгдэж, хяналтын үр дүн гарч байна.

3.1. ХЭД Сангийн хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналтыг тавьж байсны зэрэгцээ хяналтын байгууллагуудаас хяналт шалгалтыг явуулж ирсэн байна.⁶

Тайлант онд аймгийн ХХҮГазрын ХШУДАХ мэргэжилтэн Г.Эрдэнэбаяр хөтөлбөрийн хэрэгжилтээр Сант, Баян-Өндөр,Өлзийт, Баянгол, Төгрөг, Есөнзүйл, Хархорин, Хужирт, Уянга, Бат-Өлзий сумдад хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажилласан байна.

“Эх Нутаг Хөгжил” төв ТББ-аас 2015 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, үйлчилгээнд хяналт, үнэлгээг 2016 оны 05 дугаар сард явуулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүд, ХЭДСангийн сурталчилгаа, олон нийтийг хамарсан ажил зохион байгуулах зардлаас зохион байгуулсан ажил, үйлчилгээний хэрэгжилтэд хяналт, үнэлгээг хийжээ.

Аймгийн МХГазраас ХЭДСангийн үйл ажиллагааг 2015 оны шалгах хяналтын хуудсаар эрсдэл бага гэж тодорхойлжээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2016 оны 5 дугаар сард Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 2014, 2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн байна.

Мөн 2017 оны 03 дугаар сард аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус газрын 2016 оны санхүү, нийгмийн халамж, ХЭДСангийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг явуулжээ.

Аудитын газраас 2015 оны үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар 8.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага тавигдаж, биелэлтийг хангаж ажилласан байна.

3.2. Сангийн үйл ажиллагаанд тавих хяналт үр дүнгээ өгсөн байна.

Аймгийн ХХҮГазрын ХШУДАХ мэргэжилтэн Г.Эрдэнэбаяр хөтөлбөрийн хэрэгжилтээр нэр бүхий 10-н сумдад хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналтаар дараах зөрчил илрүүлсэн байна. Үүнд:

- Бүлгийн зохион байгууллattай хүнсний ногоо тариалах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Өлзийт сумын бүлгийн 2 гишүүн өөрийн хашаандaa тус тусдаа тарьсан. Хархорин сумын

⁶ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 32.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд дараах эрх бүхий байгууллага, албан тушаалтан хяналт тавина:

32.1.1.Улсын Их Хурал, Засгийн газар, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд;

32.1.2.мэргэжлийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу мэргэжлийн хяналтын байгууллага.

32.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хөндлөнгийн байгууллагаар жил бүр хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ.

Цэвэлмаа ахлагчтай Арвин ургац бүлэг, С.Батсүх ахлагчтай Ногоон Эрдэнэ бүлэг, Ч.Бямбахорол ахлагчтай Баян ургац бүлгийн гишүүд тус тусдаа үрээ хувааж тарьсан.

- Хархорин сумын иргэн С.Дашсүрэн оёдлын машинаа худалдаж аваагүй, цагаан идээний худалдаа хийдэг Н.Даваажав 100.0 хувь эргэлтийн хөрөнгөнд зарцуулсан.
- Бат-Өлзий сумын мэргэжилтэнд судалгаа, мэдээлэл, тайлан байхгүй, хяналт хийгээгүй, 3 иргэн эргэн төлөлтөө хийгээгүй байжээ.
- Хархорин суманд зарим хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй хэрэгжсэн байна. Мөн тэтгэврийн насын 2 иргэнд дэмжлэг олгосон.
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан Хархорум төслийн хэрэгжилт хангалтгүй, 2 иргэн хамтарч ажиллаагүй тус тусдаа ажилласан зөрчил гарсанд зөвлөмж өгч ажилласан байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2015 оны 03 дугаар сарын 15/51 хяналт шалгалтын удирдамжийн дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын чанар, үр дүнд үнэлгээ, дүгнэлт өгч эрсдэлгүй үнэлгээ өгчээ.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус газрын 2016 оны ХЭДСангийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг явуулахад анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх, ХЭДСангийн хөтөлбөрүүдийг дээд газрын шийдвэр, удирдамжийн дагуу зохион байгуулж, шаардлага хангасан иргэдийг хамруулах, сангийн баримтад улирал бүр дотоод хяналтыг хийж, тайланг танилцуулж хэвших гэсэн албан шаардлагыг өгсөн байна.

Мөн жил бүр аймгийн Аудитын газраас ХЭДСангийн санхүүгийн тайланд аудитыг явуулж ирсний зэрэгцээ нийцлийн аудитыг хийж, дүгнэлт, зөвлөмж, зөрчлийг арилгуулах албан шаардлага тавьж ирсэн болно.

Харин хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журамд зааснаар 2016 оны сангийн үйл ажиллагаанд мэргэшсэн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөлд танилцуулаагүй байна.

Дүгнэлт:

Өвөрхангай аймгийн ХЭДСангийн 2016 оны орлогын бүрдүүлэлт, зарим хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн хангалтгүй байна.

ХЭДСангийн үйл ажиллагааны орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт хангалтгүй байна.

1. Сангийн эх үүсвэрийг хууль, тогтоомжтой уялдуулан төлөвлөөгүй байна.
2. Сангийн орлогыг хуулийн дагуу бүрэн бүрдүүлээгүй, нөөц боломжкоо дайчлан ажиллаагүй байна.

Аймгийн ХЭДСангийн хөрөнгө хууль, журмын дагуу зарцуулагдаж, төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа ч зарим хөтөлбөр тодорхой үр дүнд хүрээгүй байна.

- 2.1. Аймгийн ХЭДС-ийн хөрөнгийг хууль, журмын дагуу хуваарилан зарцуулсан ч хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах явдал гарсаар байна.
- 2.2. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа ч зарим хөтөлбөр тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Сангийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт хийгдэж, хяналтын үр дүн гарч байна.

- 3.1. ХЭДСангийн хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналтыг тавьж байсны зэрэгцээ хяналтын байгууллагуудаас хяналт шалгалтыг явуулж ирсэн байна.
- 3.2. Сангийн үйл ажиллагаанд тавих хяналт үр дүнгээ өгсөн байна.

Зөвлөмж:

Аймгийн ИТХ-ын дарга А.Ишдорж, Засаг дарга Г.Ганболд, Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга С.Ундрах нарт:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, журмын дагуу орон нутгийн төсвөөс аймгийн ХЭДСанд төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй хөрөнгийг хуваарилан төвлөрүүлж байх.
- Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийн орлогыг бүрэн тусгахад анхаарах. Энэ талаар хууль, журмыг боловсронгуй болгох асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад хандаж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөлийн дарга О.Батжаргал-д:

- Салбар зөвлөлийн хуралдааныг дүрмийн дагуу улирал бүр 75.0 хувиас доошгүй ирцтэйгээр хуралдуулж, дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга С.Ундрах-д:

- Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийн орлогыг санд төвлөрүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулах.
- Хөтөлбөр болон сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, анхан шатны баримт бүрдлийг хангаж ажиллах.
- Хөтөлбөрийн хөрөнгийг ажлын байрыг тогтвортой нэмэгдүүлэхэд чиглүүлж, иргэдэд бодитой дэмжлэг болохуйцаар зохион байгуулах.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР